

APU COMPANY

Absolute. Pure. Unique.

Хагас жилийн тайлан
2021

АГУУЛГА

Бизнесийн үйл ажиллагаа

Компанийн эрхэм зорилго, үзэл баримтлал, үнэт зүйлс
2021 оны Удирдлагын баг
Үйл ажиллагааны хураангуй
Экспортын тойм
Ковид 19 цар тахлын үеийн эрсдэлийн удирдлага
Бүтээгдэхүүн хөгжүүлэлт

Санхүүгийн үйл ажиллагаа

Санхүү байдлын тайлан
Орлого үр дүнгийн тайлан

Компанийн засаглал

АПУ ХК-ийн бүтцэд гарсан өөрчлөлт
Хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл
Төлөөлөн Удирдах Зөвлөл
Ногдол ашгийн мэдээлэл

Тогтвортой хөгжлийн тайлан

АПУ ХК-ийн тогтвортой хөгжлийн тэргүүлэх зорилт
Ковид 19 цар тахлын үеийн нийгэмд чиглэсэн бодлого
Ковид 19 цар тахлын үеийн “Аюулгүй байдал” ба “Эрүүл мэнд”
Уур амьсгалын өөрчлөлтийг нөлөөг бууруулах
Хуурай газрын экосистемийг хамгаалах
Чанартай боловсролыг дэмжих
Хариуцлагатай хэрэглээг дэмжих

КОМПАНИЙН ЭРХЭМ ЗОРИЛГО

Absolute.^{төгс}



Pure.^{төгөлдөр}



АМЬДРАЛЫН
МӨЧ БУРИЙГ
ХАМТДАА.



Unique.^{тунгалааг}

КОМПАНИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ



Бид бүхий л түвшинд чанарыг
эрхэмлэж, хэрэглэгч, харилцагч,
хамтрагчдынхаа эрхэм сонголт байна.



Бид баяр хөөртэй, дахин
давтагдашгүй, нандин сайхан
мөчүүдийг түгээнэ.



Бид хүн, нийгэм ба эх дэлхийд ээлтэй
үйл ажиллагаа явуулж, байгальд
сөргөөр нөлөөлөх нөлөөллийг алхам
бүртээ багасгаж, гэрэлт ирээдүйг
хамтдаа цогцлооно.

КОМПАНИЙН ҮНЭТ ЗҮЙЛС

АМЖИЛТ ӨӨД ХАМТДАА.

- Бид хамтын ажиллагаа, хамтын шийдвэр гаргала, хүн бүрийн оролцоог бүрдүүлж, нээлттэй харилцааг эрхэмлэдэг.
- Харилцан итгэлцэл, хүндлэл, эерэг дулаан харьцааг бий болгон үр дүнтэй хамтран ажилладаг
- “Би” бус “Бид” зарчмыг дээдэлдэг.
- Бид аливаад хамтдаа ялахын төлөө ажилладаг ба win-win зарчмыг дээдэлдэг.

ҮЛГЭРЛЭН МАНЛАЙЛ.

- Бид хааш тэмүүлж, юунд зорьж буйгаа мэддэг.
- Бид салбар, зах зээл бүртээ манлайлахыг төлөө ажилладаг.
- Аливаад эзний ёсоор хандаж, бусдыгаа уриалан дууддаг.
- Хүн бүр манлайлагч байхыг хүсдэг, бас чаддагт итгэдэг.
- Хүн бүр бусдыг үлгэрлэн манлайлж, нөлөөлж нийгмийн өмнө хүлээсэн үүргээ гүйцэтгэдэг.

БУСДЫГ ДЭЭДЛЭН ЭРХЭМЛЭ.

- Хүнсний болон хөдөлмөрийн аюулгүй байдлыг эн тэргүүнд ханган ажилладаг.
- Бид байгаль орчиндоо ээлтэй үйл ажиллагаа явуулж, эх дэлхийгээ хайрлан дээдэлдэг.
- Бид нийгэмдээ үйлчилж, нийгмийн хөгжил дэвшилд өөрийн үнэтэй хувь нэмрийг оруулдаг.
- Бид хууль дүрмээ чандлан сахиж, шударга ёсыг эрхэмлэн ажилладаг.



УЛАМЖЛАЛАА ХҮНДЭЛ, ШИНИЙГ БҮТЭЭ.

- Бид үргэлж уламжлалаа дээдэлж, шинийг эрэлхийлж, шинэ шийдэл, шинэ бүтээгдэхүүн, шинэ үнэ цэнийг бүтээдэг.
- Ажилтан бүр нээлттэй санал санаачилга гаргаж, түүнийгээ үр дүнтэй хэрэгжүүлэх нөхцлийг бүрдүүлэн ажилладаг.
- Бид бусдаас түрүүлж, бусдаас түргэн хөдөлдөг.

СУРАЛЦ. НЭЭ. ХӨГЖ.

- Бид мэдлэг, үр чадварыг эрхэмлэн дээдэлдэг.
- Өөрийгөө болон бусдыг хөгжүүлэх нь ажилтан бүрийн эрхэм үүрэг.
- Хэрэглэгч, харилцагч, зах зээлийн талаарх мэдлэг, судалгаа, шинжилгээн дээр үндэслэн аливаа шийдвэрийг гаргадаг.
- Бид үргэлж шинийг судалж, эрэлхийлж, шинэ зах шинэ хил хязгаарыг нээхийг эрмэлздэг.

2021 ОНЫ УДИРДЛАГЫН БАГ



**ЦЭВЭЭНЖАВЫН
ЭРДЭНЭБИЛЭГ**
Гүйцэтгэх захирал



НИКОЛАЙ ДОБРЕВ
Үйлдвэрлэл, үйл ажиллагаа
эрхэлсэн захирал



ГОНЧИГИЙН ЭНХБИЛЭГ
Санхүү эрхэлсэн захирал



**ГАЛСУМЬЯАГИЙН
БАЯРМАГНАЙ**
Борлуулалт, Байгууллагын
Харилцаа эрхэлсэн захирал



АРИУНА ДАНДАРОВА
Маркетинг эрхэлсэн захирал



**ЦООДОЛЫН
ЭРДЭНЭЖКАРГАЛ**
Гадаад худалдаа эрхэлсэн
захирал



**ЖАРГАЛСАЙХАНЫ
ИЧИНХОРЛОО**
Хүний нөөц, Захиргаа
эрхэлсэн захирал



САНЖИЙН ГАНЗОРИГ
АПУ Дэйрии ХХК-ийн
Гүйцэтгэх захирал



БАТХУРЭЛИЙН ЧИНТОГТОХ
Спирт Бал Бурам ХХК-ийн
Үйл ажиллагаа эрхэлсэн захирал



БАТСАЙХАНЫ ГАНТИГ
Байгууллагын Стратеги
эрхэлсэн захирал

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХУРААНГҮЙ

Цар тахлын сорилт үргэлжилсэн 2021 онд Монгол улсын төсөвт бүрдүүлэх татварын орлого, ажлын байрыг тасралтгүй хангах, харилцагчийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, экспортын үйл ажиллагаагаа эрчимжүүлэхтэй холбоотойгоор валютын орох урсгалыг нэмэгдүүлэх зэрээр улсынхаа эдийн засагт хувь нэмэр оруулж ажиллалаа.

2021 он гарсаар дараах чиглэлд анхаарч ажиллав:

- Ковид цар тахлын үеийн менежментийн бодлого хэрэгжүүлж тэвчиж болох бүх талын зардлыг танасан нь өмнөх жилүүдтэй харьцуулсан ашгийн үзүүлэлтдэд нөлөөлөв

- Экспортын үйл ажиллагааг эрчимжүүлснээр голлох зах зээл болох ОХУ, БНХАУ дахь борлуулалтын хэмжээг огцом нэмэгдүүллээ.
- Сүү, сүүн бүтээгдэхүүний хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийг эрчимжүүлснэтэй холбоотой борлуулалт өссөн үзүүлэлттэй гарлаа.
- Тогтвортой хөгжлийн бодлогын тэргүүлэх чиглэлийг эрчимжүүлж байгаль орчин, хүн, нийгэм, харилцагч байгууллагууддаа хандсан ажлуудыг өргөн цар хүрээтэй зохион байгууллаа.



Борлуулалтын тоо хэмжээ сая.литр



Цэвэр борлуулалтын орлого тэрбум төгрөг



Үйл ажиллагааны ашиг тэрбум төгрөг



Цэвэр ашиг тэрбум төгрөг



Хөрөнгө оруулалт тэрбум төгрөг



Татвар төлөлт тэрбум төгрөг



Бүтээгдэхүүний төрөл Нэр төрлийн тоо



Ажилтны тоо



ЭКСПОРТЫН ТОЙМ

АПУ ХК нь экспортын зах зээлийн өсөлтийг эрчимжүүлэн гадаад валютын орох урсгалыг нэмэгдүүлэх замаар Монгол Улсын эдийн засагт хувь нэмэр оруулахад онцгой анхаарал хандуулан ажиллаж байна.

Зорилтот зах зээл ОХУ, БНХАУ байгаа ба ОХУ-д 2021 оны нэгдүгээр хагас жилд охин компани болох "Гранд" ХХК-иар дамжуулан борлуулалтын тоо хэмжээгээ 2 дахин өсгөөд байна.

Бид Москва, Санк-Петербург, Казань, Челябинск, Красноярск, Эрхүү, Улаан-Үдэ, Чита, Владивосток зэрэг ОХУ-ын 40 гаруй хотын худалдаа, үйлчилгээний цэгүүдээр өөрийн бүтээгдэхүүнийг худалдаалж байна.

БНХАУ дахь борлуулалтын хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад б дахин өсөлттэй байв.


Сэргүүн брэндийн шар айргийг БНХАУ-д шинэ дистрибутер компаниар дамжуулан амжилттайгаар худалдан борлуулж эхэллээ. ӨМӨЗО, Ченгду, Хайнаны Хайкоу хотуудад болсон үзэсгэлэн худалдаа, томоохон арга хэмжээнүүдэд идэвхтэй оролцож Монгол брэндийг дэлхийд таниулсаар байна.

Хэрэглэгчийн судалгаанд суурilan экспортын бүтээгдэхүүнийн сав баглаа боодлын өөрчлөлт, шугамын өргөтгөлд онцгой анхаарал хандуулан тасралтгүй шинчлэлт хийн ажиллаж байна. КОВИД-19 цар тахал компанийн хэмжээнд төдийгүй Монгол улсын экспортод том нөлөө үзүүлж байгаа хэдий ч бид төрийн байгууллагууд

болон олон улсын байгуулагуудтай хамтран хэрэглэгчийн аюулгүй байдлыг хангасан бүтээгдэхүүнийг хилийн чанадад аливаа тасалдалгүйгээр хүргэхээр хичээнгүйлэн ажиллаж байна.


ОХУ-ын Красноярск хот дахь АПУ ХК-ийн 100% хөрөнгө оруулалттай охин компани болох Гранд ХХК-ийн удирдлагуудын хамт Татспиртпром ХК-ийн удирдлагуудтай хамтын ажиллагааны шинэ түвшинг тодорхойлох стратегийн уулзалт зохион байгуулав.

Уулзалтын хүрээнд ОХУ-ын зах зээлд Татспиртпром ХК-иар дамжуулан нийлүүлж буй брэнд бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх талаар санал солилцож, технологийн өндөр түвшний стандарт, ноу-хау шингэсэн үндэсний брэнд бүтээгдэхүүнийг олон улсын хэрэглэгчдэд хүргэх асуудлаар хэлэлцлээ.



КОВИД 19 ЦАР ТАХЛЫН ҮЕИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

1. Ковид 19 - Эрсдэлийн зураглал



2. Ковид 19 цар тахалтай холбоотой томоохон эрсдэлүүд

Дэлхий дахинаа хүн амын эрүүл мэнд болон нийгэм, эдийн засаг, санхүүгийн тогтолцоо, бизнесийн орчин гээд бүхий л чиглэлд асар хүчтэй, гэнэтийн цохилт үзүүлж буй өнөө үеийн хүн төрөлхтний өмнө тулгарсан хүндэхн сорилтын нэг бол яахын аргагүй Ковид-19 цар тахал юм.

Монгол улсын хувьд урт хугацааны хөл хороо тогтоосны улмаас бизнесийн байгууллагуудын үйл ажиллагаа доголдох, тасалдах хүндрэлүүд учирч байна.

Манай компани ч мөн адил уг асуудалтай нүүр тулсан хэдий ч эрсдэлийг урьдчилан таамаглаж, үр дагаврыг бууруулах нэгдсэн аргачлалын дагуу боломжит хэмжээнд зардлаа танах, гол чиглэл рүү төвлөрөх, хуримтлал үүсгэх замаар богино хугацаанд, хурдтай шийдвэрүүдийг гарган ажиллаж байна. Ингэснээрээ бид цомхтогол хийхээс ангид байж цалингийн тасалдал үүсгэхгүй байх тал дээр анхааран, шаардлагатай ажилтнуудаа Ковид-19 даатгалд хамруулж, хэрэглэгчээ чанартай бүтээгдэхүүнээр тасралтгүй ханган ажиллаж чадсан билээ. Цаашид

бид цар тахлын дараа үе буюу Ковид-19 цар тахалтай зэрэгцэн, үүссэн нөхцөл байдалд дасан зохицож, үйл ажиллагаагаа уялдуулан ажиллах шаардлага үүсч байна.

АПУ групп компанийн хэмжээнд эрсдэлийн нэгдсэн бүртгэл үүсгэн, эрсдэлийн нарийвчилсан анализ үнэлгээ хийх, бууруулах төлөвлөгөөг боловсруулан, мөшгөлт хийх, удирдлагыг шаардлагатай мэдээллээр хангах, эрсдэлийн соёлыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор "ARM" буюу эрсдэлийн удирдлагыг автоматжуулах төслийг санаачлан амжилттай хэрэгжүүлсэн бөгөөд энэ нь цар тахлын үед зайнас ажиллах нөхцөлд нэн тохиromжтой, үйл ажиллагааг хурдатгасан ажил байлаа. Үүний үр дүнд эрсдэлийн удирдлагын процесст удирдлагуудын оролцоо нэмэгдэж, ашиглахад хялбар, хэрэглэгчийн смарт цонхтой, эрсдэлээс урьдчилан сэргийлэх гурван шатны алерттэй, нэгдсэн дашбоардтай болсноор эрсдэлийн удирдлагын чиглэлд шуурхай шийдвэр гарган, бүтээмжийг үлэмж дээшлүүлэн ажиллах болсон.

3. Ковид 19 -ийн үед компаниас авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

Санхүүгийн хувьд:

- Ямарч тохиолдолд хэмнэлтийн горимыг чангаруулах, шаардлагагүй зардлуудыг тзвчих,
- Нэн чухал чиглэлд санхүүжилт хийх
- Зээлийн болон авлагын бодлогод анхаарах,
- Урт хугацааны мөнгөн хөрөнгийн оновчтой бодлогыг хэрэгжүүлэх зэргээр ажиллаж байна.

Эрүүл, аюулгүй байдал:

- Боломжит ажилтнуудыг зайнас ажиллах горимыг хэрэгжүүлэх
- Ажлын байран дээр аюулгүй ажиллах бүхий л боломж нөхцөлийг хангах:
 - * Зай барих, маск зүүх, гарын ариун цэвэр сахих, тусгаарлах өрөө гаргах, тогтмол ариутгал хийлгэх, шаардлагатай ажилтнуудыг Ковид-19 даатгалд хамруулах, шаардлагатай мэдээ, мэдээллийг тогтмол, шуурхай өгч, ажилтнуудыг сэтгэл санаагаар дэмжин ажиллах зэргээр нэгдсэн дэг журмын дагуу ажиллуулах,

Хямралын менежмент:

- Хямралын менежмент, бизнесийн тогтвортой ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлж байна.
- Нийгмийн эрүүл мэндийг хамгаалж чанартай бүтээгдэхүүн үйлчилгээгээр тасралтгүй хангах чиглэлээр анхаарч байна.

БҮТЭЭГДЭХҮҮН ХӨГЖҮҮЛЭЛТ

Сүү, сүүн бүтээгдэхүүний зах зээлд ээлэх хувии нэмэгдүүлэх компанийн голлох стратегийн хүрээнд АПУ Дэйри ХХК-ийн шинэ бүтээгдэхүүний хөгжүүлэлтэд анхааран ажиллав.

Тухайлбал “Ард түмний хүнс” өргөмжлөлтэй “Дээж” брэнд нэр төрлөө өргөжүүлж Монгол уламжлал, инноваци хослуулсан Шар сүүний чихэр, Шанзтай Өрөм, Аарцан амттан болон Йогуртын төрлийн “Сайн” брэндийн хувилбарыг зах зээлд сэргээн нийлүүлсэн юм.



Ус, ундааны бүтээгдэхүүний шугамын өргөтгөлийг тасралтгүй хийж амьдралд тохиолдох хором мөч бурийг илэрхийлэхээр зорьдог үндэсний брэнд болох Оргилүүн брэндийн сав баглаа боодлын шинэчлэлтийг хийж хэрэглэгчдэд улам ойртоо.



Мөн бид эх орны хөрсөнд ургасан эмийн ургамлыг орц найрлаганд нь шингээн шинээр “Тайга Алтангагнуур 17%” брэндийг хэрэглэгчдэд хүргэв.



Цар тахал, албан хөл хориотой холбогдуулан хэрэглэгчдийн шинэ хэрэгцээ шаардлагад нийцсэн, эрүүл мэндэд ашиг тустай, хэрэглээг хялбаршуулсан, инноваци шингэсэн савлагаа бүхий шинэ бүтээгдэхүүнүүдийг зах зээлд гаргана хэрэглэгчдийн сонголтыг улам бүр нэмэгдүүлж ажиллаа.

Энэ дундаа компанийн “Тогтвортой Хөгжлийн Бодлого”-д нийцүүлэн зөв зохистой, хариуцлагатай хэрэглээг дэмжсэн HEINEKEN 0.0 брэндийг Монголын зах зээлд нийлүүлсэн нь компанийн хувьд алкохолгүй шар айрагны анхны шинэ бүтээгдэхүүн болсон юм.



САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Балансын бүтцэд орсон өөрчлөлтүүд:

Ковид-19 цар тахалтай холбоотойгоор харилцагчийн төлбөрийн чадвар муудаж борлуулалтын авлагын хэмжээ нэмэгдсэн. Хямралын үеийн үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу харилцагчдын санхүүгийн байдалтай танилцаж, зээлийн борлуулалтын хяналтыг чангатгах, найдвартай авлагыг бууруулах арга хэмжээ авч ажилласан.

Өр төлбөрийн хувьд түүхий эд материалын өглөгийг хойшлуулсантай холбоотойгоор нийт өр төлбөрийн хэмжээ өссөн үзүүлэлттэй байна.

ОРЛОГО УР ДҮНГИЙН ТАЙЛАН

АПУ Групп компанийн нэгтгэсэн үзүүлэлтээр борлуулалтын орлого 35%, цэвэр ашгийн хэмжээ 80% тус тус өссөн байна.

Борлуулалтын орлогын өсөлтөд шар айраг, ус, ундаа, сүү, сүүн бүтээгдэхүүний өсөлт нөлөөлсөн. Тухайлбал ус ундааны бүтээгдэхүүний борлуулалт өнгөрсөн жилээс хоёр дахин, сүү, сүүн бүтээгдэхүүний борлуулалт 22%-аар тус тус өссөн үзүүлэлттэй байна. Үнээс гадна экспортын борлуулалт өнгөрсөн жилийн мөн үеэс б дахин өсөлттэй байгаа билээ.

Улсын хэмжээнд тогтоосон хөл хорионы улмаас үйл ажиллагааны хувьд хязгаарлалтууд хийгдсэн бөгөөд энэхүү хүндрэлийг давахын тулд Групп компанийн хэмжээнд "Хямралын үеийн санхүүгийн төлөвлөлт"-ийг боловсруулан, шат дараатайгаар үйл ажиллагааны зардлуудыг царцааж хойшлуулсан нь ашигт эерэг нөлөө үзүүлсэн.

		2020Q4	2021Q2	Аудитлагдаагүй
Эргэлтийн хөрөнгө	сая.төг	204,585	242,955	
Эргэлтийн бус хөрөнгө	сая.төг	351,078	352,536	
Нийт хөрөнгө	сая.төг	555,663	595,491	
Өр төлбөр	сая.төг	94,047	114,210	
Эздийн өмч	сая.төг	461,615	481,281	
Нийт өр төлбөр ба Эздийн өмч	сая.төг	555,663	595,491	

	2020Q2	2021Q2
	Аудитлагдаагүй	Аудитлагдаагүй
Цэвэр борлуулалтын орлого	сая.төг	226,068
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	сая.төг	117,242
Нийт ашиг	сая.төг	108,825
Үйл ажиллагааны зардал	сая.төг	53,457
Үйл ажиллагааны ашиг		55,368
Үйл ажиллагааны бус ашиг, алдагдал		(1,977)
Татвар төлөхийн өмнөх ашиг		57,345
Татварын зардал	сая.төг	12,234
Татварын дараах ашиг	сая.төг	45,112
		81,299

Үйл ажиллагааны ашигийн маржин	24%	32%
Цэвэр ашгийн маржин	20%	27%

АПУ ГРУПП КОМПАНИЙН БҮТЦЭД ГАРСАН ӨӨРЧЛӨЛТ:

АПУ ХК нь Дижитал Концепт ХХК-ийн 39%-ийн хувьцаа эзэмшигчээр 2021 оны 01 сарын 20-ны өдөр бүртгүүлснээр нийт 8 охин компани, 1 хараат компанийт болов.

Дижитал Концепт ХХК нь Шунхлай групп ХХК, АПУ ХК, БНСУ-ын хуулийн этгээд болох Жи Эс Рэтайл Ко. Лтд (GS Retail Co. Ltd) -ийн хамтарсан хөрөнгө оруулалттай компани бөгөөд Монгол Улсын нутаг дэвсгэрт "GS25" 24 цагийн конвениенс дэлгүүрийн франчайзинг эрхийг эзэмшдэг.

Дижитал Концепт ХХК-ийн хувьцааны 39%-иг эзэмших асуудлыг АПУ ХК-ийн ТҮЗ-ийн хурлын шийдвэрээр сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулах журмын дагуу хэлэлцэж шийдвэрлэсэн болно.

АПУ Групп компанийн бүтэц

APU COMPANY

Absolute. Pure. Unique.



APU TRADING
Absolute. Pure. Unique.

Grand



Чингисхан
Интернэшнл
Лимитэд

APU DAIRY
Absolute. Pure. Unique.



ГРАНД ИСТ
Absolute. Pure. Unique.

DIGITAL
CONCEPT

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН МЭДЭЭЛЭЛ

Хувьцаа эзэмшигчдийн хурал

АПУ ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2021 оны 04-р сарын 23-ны өдөр цахимаар болж, дараах шийдвэрүүдийг гаргав. Үүнд:

1. АПУ ХК-ийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан “АПУ групп компани 2020 онд тавьсан зорилтуудаа бүрэн биелүүлж, амжилттай ажилласан” гэсэн дүгнэлтийг батлав.

2. АПУ ХК-ийн Дүрмийн 7-р зүйлийн 7.2 дахь хэсэгт “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг эрх бүхий байгууллагын баталсан журмын дагуу 7.2.1. танхимаар буюу хувьцаа эзэмшигчдийг биечлэн оролцуулах замаар; 7.2.2. Мэдээллийн технологийн шийдэл ашиглан зайнас буюу цахим хэлбэрээр; 7.2.3. Танхимаар ба зайнас хосолсон байдлаар зохион байгуулж болно.” гэсэн нэмэлт өөрчлөлтийг оруулж, батлав.

Нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид

АПУ ХК-ийн хувьцаа эзэмшигчид (2021 оны 06 сарын 30-ны өдрийн байдлаар)

2020 оны эцэстэй харьцуулахад нөлөө бүхий хувьцаа эзэмшигч Steppe Beverage KFT хувьцаагаа 165,807 ширгээр нэмргүүлснээр эзэмшилийн хувияа 0.02%-аар өсгөжээ.

APU COMPANY

Absolute. Pure. Unique.



МХБ-ийн 2021 оны эхний хагас жилийн арилжааны тайлан (Эх сурвалж: МХБ)

	Эрэмбэ	Тоо, хэмжээ
Зах зээлийн үнэлгээ	1	(844.35 тэрбум төг)
Хувьцааны арилжааны үнийн дүн	5	(3.6 тэрбум төг)

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

**ПҮРЭВИЙН БАТСАЙХАН**

ТУЗ-ийн Ердийн гишүүн бөгөөд
ТУЗ-ийн дарга

Шунхлай групп ХХК-ийн Ерөнхийлөгч
Скайтэл ХХК-ийн ТУЗ-ийн дарга, гишүүн
2002 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-ийн дарга

**БҮРЭНТОГОХЫИН БАТБАЯР**

Шунхлай групп ХХК-ийн Санхүү эрхэлсэн захирал
2013 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүн

**СЕРГЕЙ ГРОМОВ**

Монгол Даатгал ХК-ийн ТУЗ-ийн дарга
2013 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-ийн
гишүүн

**КЕННЕТ ЧУ**

Хайнекен Азия Пасифик компанийн Ази-Номхон
далайн бүс хариуцсан Гүйцэтгэх захирал
2018 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүн

**СЭН И-ИН**

Хайнекен Азия Пасифик компанийн Ази-Номхон
далайн бүсийн Хууль Эрх Эзүй хариуцсан захирал

**ТОМАС ХОЛЛАНД**

Девелопмент Финанс Азия компанийн Хөрөнгө
оргуулалт хариуцсан захирал, Гүйцэтгэх захирал
2019 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүн

**ӨЛЗИЙДЭЛГЭРИЙН БАТБАЯР**

Баттур Трейвл ХХК, Улаанбаатарын эх газар
ХХК-ийн Ерөнхий захирал
Бату Дижитал ХХК-ийн ТУЗ-ийн дарга
2017 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүн

**ЁНДОН-ОЙДОВЫН
ГЭРЭЛЧҮЛҮҮН**

Нээлттэй хот ТББ-ын үсгэн байгуулагч
2017 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-ийн гишүүн

**ЖИГЖИДИЙН ҮНЭНБАТ**

2013 оноос хойш АПУ ХК-ийн ТУЗ-ийн
гишүүн

**ЧАДРААБАЛЫН
АРИУНСАН**


ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга

НОГДОЛ АШГИЙН МЭДЭЭЛЭЛ

АПУ ХК-ийн ТҮЗ-ийн 2021 оны 02 сарын 15-ны өдрийн шийдвэрээр компанийн 2020 оны хоёрдугаар хагас жилийн үр дүнд үндэслэн нэгж хувьцаанд 57.50 (тавин долоон төгрөг тавин мөнгө) төгрөгийн ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэж, ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалт гарах бүртгэлийн өдрийг хувьцаа эзэмшигчдийн 2021 оны ээлжит хурлын бүртгэлийн өдөр (2021 оны 03 сарын 31)-өөр тогтоож, ногдол ашгийг 2021 оны 12 сарын 31-ний дотор олгохоор тогтсон.

Ногдол ашгийн төлбөрийг нийт хувьцааны таваас доош хувийг эзэмшигчдэд "Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв" ХХК-аар зуучлуулан 2021 оны 06 сарын 15-ны өдөр тараасан ба таваас дээш хувийг эзэмшигчдэд компаниас шууд төлөх замаар мөнгөн хэлбэрээр олгож байна.

Ногдол ашгийн хуваарилалт (2018 оноос хойш)



АПУ ХК-ИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ТЭРГҮҮЛЭХ ЗОРИЛТ

Эх дэлхийгээ мөнхөд ногооноор нь хадгалъя.

Дэлхий даяар бизнесийн үйл ажиллагаа явуулах нь зөвхөн ашгийн төлөө бус түүнийг давсан хариуцлагыг шаарддаг.

Бид 2021 онд НҮБ-аас баталсан дэлхийн улс орнууд бүх нийтээр дэмжин хүн бүрт хөгжил цээглэлтийг хүртээмжтэй байлгах, ядуурлыг бууруулах, эх дэлхийгээ хамгаалахыг зорьж буй тогтвортой Хөгжлийн 17 зорилтыг хэрэгжүүлэх хүчин чармайлтаяа эрчимтэй нэмэгдүүлэн ажиллаж байна.

Бидний зорилго бол эх дэлхийдээ үзүүлэх аливаа серөг нөлөөллүүдийг хязгаарлаж, нийгэм, эдийн засагт оруулах эерэг хувь нэмрийг улам нэмэгдүүлэх явдал юм.

АПУ ХК-ийн ажиллагсад, харилцагчид, хамтран ажилладаг түнш байгууллагууд, ханган нийлүүлэгчид, төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагууд зэрэг тал бүрийн хамтын хичээл зутгэл нь урт хугацаанд үргэлжлэх бодит үр дүнд хүрэх зам юм.

Бидний төвлөрөх зургаан чиглэл нь Тогтвортой Хөгжлийн Зорилтуудтай уялдах тул бид ил тод байдал, хамтын зөвшилцэл, хамтын шийдлийг чухалчлах болно.

2021 онд бид тэргүүлэх чиглэл, стратегийнхээ дараагийн үе шатыг тодорхойлохоор ажиллаж байна.

МОНГОЛ УЛСЫН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТ

"Тогтвортой хөгжил -2030 хөтөлбөр"-ийг анх 2012 онд Рио Де Жанейро хотод улс орнуудын төрийн тэргүүнүүд оролцсон НҮБ-ын "Тогтвортой хөгжил" бага хурлын үеэр санаачилсан. Тогтвортой хөгжлийн зорилго (TX3) нь 2015 онд хэрэгжилтийн хугацаа нь дуусгавар болж буй "Мянганы хөгжлийн зорилтууд"-ын үргэлжлэл юм. 2015 онд НҮБ-ын Ерөнхий Асамблейн 70 дугаар чуулган болж, TX3-ын 17 зорилго, 169 зорилтыг баталж, 2016 оны 1 сарын 1-нээс "Тогтвортой хөгжлийн зорилго" (TX3) албан ёсоор дэлхий нийтээр хэрэгжиж эхэлсэн.



БИДНИЙ 2021 ОНЫ ЗОРИЛТ:

Ковид 19 цар тахлын үеийн нийгэмд чиглэсэн бодлого



Ковид 19 цар тахлын үед хэрэглэгч, харилцагч, олон нийтэд чиглэсэн төсөл хөтөлбөрүүдээ эрчимжүүлэв

Цар тахлын нөхцөл байдлаас хамааран өдрийн орлого нь тасалдсан зорилтолт бүлгийн айл өрхүүдэд тусламж дэмжлэг үзүүлэхийн зэрэгцээ харилцагч, хэрэглэгчдэд чиглэсэн хөрөнгө оруулалтын төсөл хөтөлбөрүүдэд онцгой анхаарал хандуулж ажиллалаа.

Ковид 19 цар тахлын үеийн "Аюулгүй байдал" ба "Эрүүл мэнд"



Цар тахлын үеийн ажилтнууддаа чиглэсэн эрүүл мэнд, аюулгүй байдлын бодлого

Цар тахлын үеийн бодлогод онцгой анхаарал хандуулж ажилтнуудаа шуурхай вакцинд хамруулж, аюулгүй байдлыг ханган, халдварт хамгааллын дэглэмийг чанд мөрдөн ажиллаж байна.

Ур амьсгалын өөрчлөлтийг нөлөөг бууруулах



Дотоод ажилтнууддаа зориулсан "Мод бид хоёр" төсөл

Ур амьсгалын өөрчлөлтөд хамгийн ихээр нөлөөлж буй цөлжилт, хуурайшилтын эсрэг компанийн дотоод ажиллагсдын хувийн ногоон байгууламжид хөрөнгө оруулж мод, зүлгээр хангахын зэрэгцээ тогтмол арчлан ургуулах сургалт мэдээллээр хангав.

Хуурай газрын эко системийг хамгаалах



Экологийн Цагдаагийн албатай хамтарсан "Байгаль Эн Тэргүүнд" төсөл

Тогтвортой хөгжлийн зорилго болох Хуурай газрын эко системийг хамгаалах, тэр дундаа биологийн олон янз байдлыг хангахын тулд ховордсон ан амьтныг хамгаалах чиглэлээр "Байгаль эн тэргүүнд" төслийг Экологийн Цагдаагийн албатай хамтран амжилттай хэрэгжүүллээ.

Чанартай боловсролыг дэмжих



Нийгмийн эерэг өөрчлөлтөд манлайлагч оюутан залуусыг дэмжих "Маргаашийн Манлайлагчид" төсөл

"Тогтвортой Хөгжил"-ийн үндсэн суурь зарчимд (Зорилго 4. Хүртээмжтэй, тэгш чанартай боловсролоор хангах, хүн бүрийн насан туршдаа суралцах боломжийг дэмжин хөхүүлэх) түлхэц өгөх зорилгоор 100 оюутанд тэтгэлэг өгөхөөр зарлав. Тэтгэлэгт хөтөлбөрийн хүрээнд эхний шатанд 1500 гаруй оюутан материал ирүүлсэн бөгөөд бид шалгарсан 100 оюутнуудтайгаа байгаль эх дэлхийдээ ээлтэй, нийгмийн эерэг өөрчлөлтийн төлөөх шийдлээ хүлээж буй олон асуудлуудад гарц гаргалгаа гарган хамтран ажиллах болно.

Хариуцлагатай хэрэглээг дэмжих



Хүн, байгаль, хүрээлэн буй орчиндоо ээлтэй соёлыг түгээх "Соёлоор Гоёно" төсөл

Урлаг, соёл, бизнес, хүний эрхийн салбарын олон талт хамтын оролцоотойгоор бидний нийгэмд шаардлагатай соёлыг тодорхойлж, ухамсар сэтгэлгээ, хандлага өөрчлөх, хариуцлагатай, үнэт зүйлтэй амьдралын хэв маягийг сурталчлан таниулах нөлөөллийн ажлыг шат дараатайгаар зохион байгуулж байна.

КОВИД 19 ЦАР ТАХЛЫН ҮЕИЙН НИЙГЭМД ЧИГЛЭСЭН БОДЛОГО



Ковид 19 цар тахлын үеийн нийгэмд чиглэсэн ээлтэй бодлого

Бидний зорилт:

Ковид 19 цар тахлын үед хэрэглэгч, харилцагч, олон нийтэд чиглэсэн төсөл хөтөлбөрүүдээ эрчимжүүлэв

“Дэм дэмэндээ-2” аянд нэгдэн өдрийн орлого тасалдсан иргэдэд тусlamж үзүүлэв.

Коронавируст цар тахлын нөлөөллийн улмаас ажлын байр нь түр хаагдсан, орлого нь тасалдсан айл өрхүүдэд тусlamж үзүүлэх зорилгоор “Дэм дэмэндээ-2” аян нийслэлийн хэмжээнд өрнүүлсэн. Энэхүү аяны эхлэл болж АПУ ХК 500 багц хүнсний тусlamжийг үзүүлж Сонгинохайрхан дүүргийн Засаг даргад хүлээлгэн өгч хүнс, ахуйн хэрэглээний тусlamжийн багцыг дүүргийн 43 хорооны 500 өрхөд хүлээлгэн өглөө.



TX3-д оруулж буй хувь нэмэр:



Дархлаажуулалтын амин хүнс “Д” витаминтай сүүг ашгийн нэмэгдэлгүй хүргэв.



Судалгаагаар монголчуудын 90 гаруй хувьд нь Д амин дэмийн дутагдалтай гэж гарсан байдаг.

Тиймээс цар тахлын үетэй холбогдуулж “АПУ Дэйри” компани худалдан авагчдынхаа дархлааг дэмжихээр “Д” витаминаар баялаг “САЙН” сүүгээ үйлдвэрийн өртгөөр хүнсний дэлгүүрүүдэд 2 сарын турш худалдаалсан юм.

Харилцагчдын мэдлэг, боловсролд хийх хөрөнгө оруулалт

Монгол улсын шингэн хүнсний салбарт тэргүүлэгч, экспортын чиг баримжаатай үйлдвэрлэл эрхлэгч АПУ ХК нь Монгол орны өнцөг буул бүрт буй бизнес эрхлэгч, **10 мянга гаруй** харилцагчдынхаа мэдлэг оюунд хөрөнгө оруулалт хийж, салбарын хөгжилд бодитоор хувь нэмэр оруулах зорилгоор “Амжилтын төлөө Хамтдаа 2021” цахим хэлэлцүүлэг зохион байгуулж олон нийтэд хүргэв.

Уг хэлэлцүүлгээр цар тахлын хүнд үед сорилт, бэрхшээлийг хэрхэн даван туулах талаар худалдаа үйлчилгээ эрхлэгчид, бизнесийн салбарынхан, сэтгэл зүйч, брэнд бүтээгчдийн төлөөлөл оролцож бодитоор нүүр тулсан хүндрэлүүдийг

2021.05.05 19:00 - 20:30 цаг		АМЖИЛTYН ТӨЛӨӨ ХАМТДАА 2021		Холбогдуулж АПУ COMPANY	
				Шинэ нехцэл байдал, Шинэ сорилт Шинэ бизнесийн боломж ЦАХИМ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ	
МОДЕРАТОР	ПАНЕЛИСТ	ГАЯАРМАГНАЙ	ДЖУЛАН САМБУЛДОРЖ	Р.ИНХУЧИШИН	С.БАТНИХ
В.БАЯРСАЙХАН	Ц.МОНДБААР	И.МОНГОД	С.БАТНИХ		

хэрхэн боломж болгон хувиргах талаар зөвлөгөө, мэдээлэл өгч нийт **700 гаруй мянган** хүнд хүрлээ.

“АЮУЛГҮЙ БАЙДАЛ” БА “ЭРҮҮЛ МЭНД”



Ковид 19 цар тахлын үеийн “Аюулгүй байдал” ба “Эрүүл мэнд”

Бидний зорилт:

Цар тахлын үеийн ажилтнууддаа чиглэсэн эрүүл мэнд, аюулгүй байдлын бодлогод анхаарах

TX3-д оруулж буй хувь нэмэр:



Бидний үйлдвэрлэл, ўйл ажиллагаандaa баримтлах зарчим бол “Аюулгүй байдал үргэлж нэгт” юм.

Аюулгүй байдлын манлайлал

2021 онд АПУ компани “Аюулгүй ажиллагааны манлайлагч” аяныг 2 дахь жилдээ зохион байгуулж байна.

Аюулгүй ажиллагааны санал санаачилга гарган, эерэг зөв хандлагаар аюулгүй ажиллах технологийг өөртөө болон бусдад зурсшил болгоход чиглэсэн, тасралтгүй З сар үргэлжлэх аянд хамрагдаж буй Борлуулалтын газрын 127 ажилтан (худалдааны төлөөлөгч, мерчиндайзер, аудитор) болон Агуулах, тээвэр түгээлтийн албаны 134 жолооч амжилттай оролцож байна.

Ослын давтамж

Манай ослын давтамж 2021 оны эхний хагас жилийн байдааар 100 хүн тутамд 0.0 үзүүлэлттэй байна. Энэ нь 2020 онтой харьцуулахад 100%-иар буурсан (100 FTE тутамд 0.19) бөгөөд бид 2021 оны зорилтоо биелүүлсэн гэсэн уг юм.

Алдагсан цаг хугацааны ослын давтамж (100 FTE тутамд осол)

Осол	Давтамж (100 FTE тутамд)
2021	0.0
2020	0.19
2019	0.46
2018	1.42

Эхний хагас жилийн байдааар хөдөлмөрийн чадвар алдарт үссэн осол бүртгэдэгүй, ажлын байран дээр анхны тусламж аваад ажлаа үргэлжлүүлсэн жихиг бэрлийн тохиолдол 7 бүртгэгдсэн байна.

2021 оны эхний хагас жилд ослын тохиолдлууд буурсан нь COVID-19 цар тахлын үеийн хөл хороо, хязгаарлалттай холбоотой. Хөл хороо болон хязгаарлалтын хугацаанд ажилтнуудыг аль болох зайнаас ажиллуулах бодлого баримтлан гэрээсээ ажиллах нөхцөл бололцоогоор хангасан.

Бидний эрсдэлд сууринсан аюулгүй байдлын стратеги

2021 онд бид аюулгүй байдлын шинэ стратегиа эхлүүлсэн. Шинэ стратеги нь бидний хамгийн өндөр эрсдэлд төвлөрч, бүх хүмүүсээс идэвхтэй оролцоо шаардаж байгаа бөгөөд замын хөдөлгөөний аюулгүй байдал, жолоодлого, гэрээлэгчийн аюулгүй байдал, аюулгүй байдлын манлайлал гэсэн гурван том эрсдэлийг бууруулах хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн. Эдгэр гурван хөтөлбөрийг амжилтай хэрэгжүүлснээр бид аюулгүй байдлын үзүүлэлтүүдээ мэдэгдхүйц сайжруулж чадна гэж үзэж байна. Бид ўйл ажиллагааныхаа эрсдлийг удирдах хангалттай чадвхийг бий болгохын тулд хүн бүр, тэр дундаа манай компанийн удирдлагасаас идэвхтэй оролцоо шаардагдана. Урьдчилан сэргийлэх арга хэмжээ авсан ч осол аваар гарч болзошгүй тул ажиллах аюулгүй орчныг манай хүмүүс л бүрдүүлэх юм.

Дэлхийн аюулгүй байдлын өдөр

Бид 2021 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр Дэлхийн Аюулгүй байдлын өдөрлөг зохион байгуулж, ‘Аюулгүй ажиллаад аж жаргалтай харьцаага’ санаачилгыг бүх түвшний манлайлалаар хэрэгжүүлж, дотоод сувгуудаар аюулгүй байдлыг хангах уриалга, тэмцээнийг зохион байгуулсан.

Гэрээлэгчийн аюулгүй байдал

Бид дэлхийн стандартаар дамжуулан гүйцэтгэгч, туслан гүйцэтгэгчдийн аюулгүй байдлыг хангах үүднээс Гүйцэтгэгчийн аюулгүй байдлын шинэ стандартыг нэвтрүүлсэн. Энэ нь өндөр эрсдэлтэй ўйл ажиллагаанд төвлөрч, гэрээлэгчдийн мэргэшлийн болон менежментийн ўйл явцыг оновчтой болгодог.



Хөдөлгөөний аюулгүй байдал

Монгол улсад жил тутам 20 мянга орчим зам, тээврийн осол бүртгэгддэг ба уг ослоос шалтгаалан 2020 онд 430 хүн амь насаа алдсан байна. (Эх сурвалж: ТЦА-ны эмхэтгэл)

Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үүднээс тээврийн хэрэгсэл болон хөдөлгөөний аюулгүй байдлын үзлэг, шалгалтыг байнга хийн аюулгүй байдлыг хангахад анхаарч ажиллаж байна.

“АЮУЛГҮЙ БАЙДАЛ” БА “ЭРҮҮЛ МЭНД”



Ковид 19 цар тахлын үеийн “Аюулгүй байдал” ба “Эрүүл мэнд”

Бидний зорилт:

Ковид 19 цар тахлын үед ажилтнуудаа 100% вакцинжуулалтад хамруулах, Амь насаа хамгаалах дүрмийг бүрэн дагаж мөрдөх



HEINEKEN-ийн амь насаа хамгаалах дүрмүүд нь манай компанийд ажилладаг бүх хүмүүст хамаатай аюулгүй ажиллагааны дүрмүүд юм. Эдгээр нь эрсдэлийг бууруулах хөтөлбөрөөр дэмжигддэг бөгөөд ноцтой, хүний амь нас алдах ослоос урьдчилан сэргийлэх түлхүүр юм.

Үйл ажиллагаа эрхэлдэг бүх компаниуд Амь насаа хамгаалах дүрмийг дагаж мөрдөх ёстай. 2021 онд бид үйлдвэрлэл үйл ажиллагаанд амь насаа хамгаалах 12 дүрмийг бүрэн мөрдөн ажиллаж байна.

TXZ-д оруулж буй хувь нэмэр:



HEINEKEN Амь Насаа Хамгаалах 12 Дүрэм

Сотгүүрийн, мисцеруулж хийжин

Сурвалж буюу нуу, компонентын чийгчилж чадац

Эргэж, замшижирдсан болжин

Мөнгөржүүлийн ялангуяа бригадийн хамгаалж хийжин

Хэлэгээрээрээний бригадийн хамгаалж хийжин

Холуун очижин газарчилж чадац

Железнодорожийн орлогод чадац

Зохицагчадан хувьзарсан

Машин төгөн төхөвчийнийн авсар Улсын төхөн цэвэр, тайл, хот

Онцлогийн инженерийн узувсгалын орлогод чадац

Саралж очижин шиншилжүүлж бөхийн хамгаалж чадац

HEINEKEN

APU COMPANY
Absolute. Pure. Unique.

PUT
SAFETY FIRST!

Аюулгүй системийг хөгжүүлэх

Аюулгүй ажлын систем нь манай хүмүүсийг аюулгүй байлгахад чухал үүрэг гүйцэтгэдэг. Дэлхийн үйл явцын аюулгүй байдлын нийгэмлэгийг Үйл ажиллагааны аюулгүй байдлын төвөөс дэмжин хөгжүүлж байна. Бид эрсдэлийн хувилбаруудад дун шинжилгээ хийх, харилцан ойлголцох, эрсдэлийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэхэд эрсдэлийг үнэлэх аргыг боловсруулан, аюулгүй ажиллагааны ‘Эрдэлийг үнэлэх аргачлал’-г нэвтрүүлэв.



Аюулгүй жолоодлогын МАНЛАЙЛАГЧ

2021



Аюулгүй байдал, эрүүл мэндийн арга хэмжээ

Монгол улсад 2021 оны эхний хагас жил коронавирусын цар тахлын тархалт огцом нэмэгдэж хүн ардын эрүүл мэнд, эдийн засагт сөрөг нөөлөлөл үзүүлсэн. Бид 2021 оны эхний хагас жилд компанийнхаа нийт ажилтнуудыг коронавирусын эсрэг вакцинд хамруулах компанийн ажилыг хохион байгуулснаар 5-р сарын байдлаар нийт ажилтнуудынхаа 92 хувийг вакцинд хамруулсан.

Мөн халдвартархалтад эрсдэлээс сэргийлэх зорилгоор ариутгал, халдвартаргүйжүүлэлтийн тоног төхөөрөмжүүдээр ажлын орчныг тоноглон шаардлагатай арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн байна.

Эхний хагас ажилд 1480 ажилтнаа коронавирусын халдвартын даатгалд хамруулжээ.

УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН НӨЛӨӨГ БУУРУУЛАХ



“Мод бид хоёр” төсөл

Бидний зорилт:

АПУ ХК нь уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, агаарын бохирдлыг бууруулах зорилгоор 2030 он гэхэд 100,000 мод тарих зорилготой


АПУ компани уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг “Ногоон соёлыг түгээ” уриатайгаар ‘Мод бид 2’ төслийг амжилттай хэрэгжүүлж байна. Уг төсөл нь эхний ээлжинд ажиллагдынхаа хашаанд мод, зүлэг тарих улмаар тэдний хөрш айлуудад нөлөөлөл бий болгон улмаар ногоон гудамж, хотыг бий болгох алсын зорилготой төсөл юм.




ТХЗ-д оруулж буй хувь нэмэр:



Уг санаачлагыг ажиллагсад таатай хүлээн авч гэр бүлийнхээ гишүүн мэт хайллан ургуулахаа илэрхийлсэн бол ногоон байгууламжийг бүтээхэд гар бие оролцон ажилласан, төслийг гүйцэтгэсэн компани хүнд хэцүү цаг үед жижиг дунд бизнесийг дэмжин хамтран ажилласанд талархаж буйгаа илэрхийлж байлаа.



Уг төслийг цаашид урт хугацаандаа хэрэгжүүлэх бөгөөд ажиллагсад, тэдний хөрш зэргэлдээ айлууд, харилцагчид зэргээр үе шаттайгаар ногоон соёлыг түгээн ажиллахаар төлөвлөөд байна.



ХУУРАЙ ГАЗРЫН ЭКОСИСТЕМИЙГ ХАМГААЛАХ



Экологийн Цагдаагийн албатай хамтарсан “Байгаль Эн Тэргүүнд” төсөл

Бидний зорилт:

АПУ ХК нь “Тогтвортой хөгжлийн бодлого”-ын хүрээнд НҮБ-аас баталсан Тогтвортой хөгжлийн 15-р зорилго болох Хуурай газрын эко системийг хамгаалах, тэр дундаа биологийн олон янз байдлыг хангахын тулд ховордсон ан амьтныг хамгаалах чиглэлээр “Байгаль эн тэргүүнд” төслийг Экологийн Цагдаагийн албатай хамтран амжилттай хэрэгжүүлэв.

“Байгаль эн тэргүүнд” төслийн хүрээнд загас агаанурын зохиистой дадал, хөвшил бий болгох, үргжлийн үед агнажгүй байх ач холбогдлыг олон нийтэд ойлгуулах, гол, мөрний экосистемийн тэнцвэртэй байдлыг хангахын тулд загасаа хайрлан хамгаалах, өсгөн үргжүүлэх ойлголт, мэдээллийг сайжруулах зорилгоор



ТХЗ-д оруулж буй хувь нэмэр:



Хуурай газрын экосистемийг хамгаалах



“Байгаль орчин, аялал зуучлалын яам, Шинжлэх ухааны академийн Гео-Экологийн хүрээлэн, Хөдөө Аж Ахуйн Их сургууль”-тай хамтран мэдээ, мэдээлэл түгээх, эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах, судалгаа мэдээллийг сайжруулах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Мөн угтөслийнхүрээнд “Зэрлэгамьтдаа хайрлая” аян зохион байгуулж хууль бусаар ан агнах гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, биологийн олон янз байдлыг хамгаалах, нөхөн сэргээх, зүй зохиистой ашиглах болон бүх нийтийн экологийн боловсролыг дээшлүүлэхийг зорьлоо.



Монгол улсын “Амьтны тухай хууль”-ийн 9, 10, 11, 12 дугаар зүйлийг хэрэгжүүлэх зорилгоор зохион байгуулсан “Зэрлэг амьтдаа хайрлая” болон “Үржлийн үед барихгүй” арга хэмжээнүүд нь иргэдийн байгаль орчинтой зөв харьцаж, хамгаалах мэдлэг ойлголтыг нэмэгдүүлсэн, буруу дадал хандлагыг сайжруулж эергээр нөлөөлсөн, зөв үйлдэлд уриалж сэдэлжүүлсэн ажил болсон гэж Экологийн Цагдаагийн албанаас онцолсон юм.

ЧАНАРТАЙ БОЛОВСРОЛЫГ ДЭМЖИХ



Нийгмийн эерэг өөрчлөлтөд манлайлагч оюутан залуусыг дэмжих “Маргаашийн Манлайлагчид” төсөл

Бидний зорилт:

Нийгмийн эерэг өөрчлөлтөд манлайлагч оюутан залуусын боловсролд хөрөнгө оруулж, сурч, хөгжих, нийгэмдээ ээлтэй ўлс хийх боломжоор хангах

ТХЗ-д оруулж буй хувь нэмэр:



Тэгш, хүртээмжтэй боловсролыг дэмжих

АПУ ХК нь 2021 онд “Хүний хөгжлийн тогтвортой бодлого”-д онцгойлон анхаарч, нийгэмд эерэг өөрчлөлтийг авчрах манлайлагчдыг нээн илрүүлэх, тэднийг сурч боловсроход нь дэмжлэг үзүүлэх зорилгоор 100 оюутны тэтгэлэгт хөтөлбөр зарласан.

АПУ ХК-ийн нэрэмжит тэтгэлэгт хөтөлбөр нь мэргэжил болон курс харгалзахгүй өргөн цар хүрээнд болж байгаагаараа онцлог бөгөөд нийгэм, олон нийтийн ажилд идэвхтэй оролцдог, сургуульдаа тогтвортой суралцах зорилготой байх гэсэн маш энгийн шалгуурыг хангасан байх ёстай.

Тэтгэлэгт хөтөлбөрт шалгарсан оюутан бүтэн 10 сарын турш амьжиргааны зардал бүхий тэтгэлэг авахаас гадна уг тэтгэлэгт хөтөлбөрийн хамтрагч байгууллагуудын ўйл ажиллагаатай танилцах дадлага ажил хийх, холбогдох сургалт, хөтөлбөрүүдэд хамрагдах ба цаашлаад АПУ ХК-нд ажиллах боломжтой болох томоохон ач холбогдолтой юм.

Энэ нь “Тогтвортой Хөгжил”-ийн үндсэн суурь зарчимд (Зорилго 4. Хүртээмжтэй, тэгш чанартай боловсролоор хангах, хүн бүрийн наасан туршдаа суралцах боломжийг дэмжин хөхүүлэх) түлхэц өгөх явдал юм. Тэтгэлэгт хөтөлбөрийн хүрээнд эхний шатанд 1500 гаруй оюутан материал ирүүлсэн бөгөөд бид түүнээс шалгарсан 100 оюутнуудтайгаа нийгмийн шийдлээ хүлээж буй олон асуудлуудад гарц гаргалгаа гарган



Сайн байна уу?
Танд энэ өдрийн минд хургэе,

Та АПУ ХК-ас санчлан хэрхүүжүүлж буй “Маргаашийн Манлайлагчид” тэтгэлэгт хөтөлбөрийн 2-р шатны шалгаруулалтын үр дүнг 8-р сард танилцуулахаар бэлтгэл ажлаа ханган ажиллаж байна.

Хөбөдүүдэр шатанд анкеты асуултанд байсан “Нийгмийн хамтны том асуудал, түүний шийдвэр гаргалгаас” асуултанд хариулсан видео бичигдээр шалгаруулна.

Бичигдээг шалгаруулсан
1. Миний нийтийн байж

✓ Энэл хисэг өөрчлөв танилцуулж /бичигийн хугацаанд тохиолдож/

✓ Түүхэндээсээсээ хамгийн чухал түүхэндээсээсээ хамгийн чухал болох бий

✓ Шийдвэр гаргалгаа на хөхжүүжүүлж болохуй байх, ур дун нь нийгээд хөхжүүжүүлж болохуй байх

✓ Бичигийн 1080НО хотогдившиноор дуу дурдийн чамартай хийж байх

Бичигийн 2021 он 6-р сарын 28-ны 16 цаг цагт

leadersofmargashin.mn/tilt/ийн хийж хөтөр, ленжэр хулжсан авна.

Танд амжилт хүсье.

хамтран ажиллах болно.

“Маргаашийн манлайлагчид” тэтгэлэгт хөтөлбөрийн 2-р шатны шалгаруулалтын үр дүнг 8-р сард танилцуулахаар бэлтгэл ажлаа ханган ажиллаж байна.



APU COMPANY

Absolute. Pure. Unique.



МАРГААШИЙН МАНЛАЙЛАГЧИД

100 ОЮУТНЫ ТЭТГЭЛЭГТ ХӨТӨЛБӨР

ОЮУТНЫ ТЭТГЭЛЭГТ ХӨТӨЛБӨР

Нийгмийн эерэг өөрчлөлтийг хамтдаа бүтээе!

Өргөдөл хүлээн авах хугацаа:
2021.05.31

ХАРИУЦЛАГАТАЙ ХЭРЭГЛЭЭГ ДЭМЖИХ



Хүн, байгаль, хүрээлэн буй орчиндоо ээлтэй соёлыг түгээх "Соёлоор Гоёно" төсөл

Бидний зорилт:

АПУ ХК нь нийгмийн ээрэг өөрчлөлтийг соёлын нөлөөллөөр бий болгох замаар хариуцлагатай хэрэглээг бүх талаар дэмжин сурталчлахыг зорж байна.

Соёлоор Гоёно

АПУ ХК нь баримтлах үнэт зүйлсдээ тулгуурлан 2021 оноос дараах үндсэн гурван чиглэлийн хүрээнд нийгмийн ээрэг өөрчлөлт бий болгох нөлөөллийн кампанит ажлуудыг үе шаттайгаар зохион байгуулж байна:

- Байгаль орчинд ээлтэй соёл / хоггүй аялах, байгальд хог тарихгүй байх, хүрээлэн буй



TX3-д оруулж буй хувь нэмэр:



Байгаль дэлхийдээ хог, хаягдал үлдээхгүй төлөө АПУ ХК-ийн бүтээгдхүүний худалдан авалт тутамд ЭКО уут бэлзгэж байна.
Хотгуй соёлын бүтээ...



Орчин цагийн соёлт хүний нэрийн хуудас байгаль эх дэлхийгээ хайлрах соёлоос эхлэнэ. Эх дэлхийгээ хайлрах, хоггүй, цэвэр цэмцгэр аялах соёлыг урлагаар дамжуулан уриалах "Соёлоор гоёно" цувралыг зохион байгууллаа



орчиндоо ээлтэй амьдрах/ Урлаг, загвар, бизнесийн салбарынхан тэргүүтэй олон талт оролцоог бэхжүүлж өв соёлыг түгээн дэлгэрүүлэх, амьдрах хэв маяг, хариуцлагатай, ээлтэй соёлыг түгээн дэлгэрүүлэх, ухамсар, хандлагад нөлөөлөх Хариуцлагатай хэрэглээний соёлыг түгээн дэлгэрүүлэх

Шилээ дахин амьдруулъя

Байгальд ээлтэй хариуцлагатай хэрэглээг дэмжиж, хог хаягдлыг бууруулах "Шилээ дахин амьдруулъя" хөтөлбөр хэрэгжүүлж, тойрог эдийн засгийг дэмжиж 2 дахин өндөр үнэр бүтээгдэхүүнийхээ шилийг хэрэглэгчдээс буцаан худалдан авах урамшууллын хөтөлбөр зарласан. Үүнээс гадна Монгол-Германы ашигт малтмал, технологийн их сургуультай хамтран "Монголд шилэн савалгаа дахин ашиглах тогтолцооны техник, эдийн засгийн боломжийг судлах" төслийг эхлүүлээд байгаа бөгөөд уг төслийн үр дүнд АПУ ХК-ийн бүтээгдэхүүний савалгааны байгальд үлдэх ул мөрийг эдийн засгийн тооцоотойгоор бодитой багасгах боломж бүрдүүлэхийг зорж байна. Эхний хагас жилийн байдлаар бид нийт б сая гаруй ширхэг шил татан авсан байна.



Хог хаягдал

АПУ ХК нь хог хаягдлын менежментийг үйлдвэрлэлээс гарч буй бүх төрлийн хатуу хог хаягдлын хүрээнд хэрэгжүүлдэг ба хог хаягдлын хэмжээг бууруулах, ландфиллд хаягдах хаягдлыг багасгах, дахивар хог хаягдаа эргүүлэн ашиглах, дахин боловсруулахад чиглэн ажиллаж байна. Үүний хүрээнд үйлдвэрлэлийн хог хаягдлын хэмжээ энэ үеийн өмнөхтэй харьцуулахад 27% -иар буурсан байна. Бид хог хаягдаа дахивар болон идэвхгүй хаягадал зэргээр дөрөвнөн төрөлд ангилж, цааш нь дахин боловсруулагдах хог хаягдлыг хоёрдогч болон дахин боловсруулах компанийд руу нийлүүлдэг. Тухайлбал аюулт болон химиин хорт бодисын сав баглаа боодол болон хаягадал шилийг дахин боловсруулах үйлдвэрүүд руу тус тус нийлүүлдэг боллоо. Үйлдвэрлэлээс гарч буй органик түүхий эд болох улаан буудай, арвайн соёолжийн үлдэгдлийг малчид фермерүүдэд, хөрөнгө, шаарыг тэжээлийн үйлдвэрт тогтмол нийлүүлж байна.



ХАРИУЦЛАГАТАЙ ХЭРЭГЛЭЭГ ДЭМЖИХ



Бага болон алкохолгүй бүтээгдэхүүний инновацыг түүчээлэх

Бидний зорилт:

АПУ ХК нь нийгмийн эерэг өөрчлөлтийг соёлын нөлөөллөөр бий болгох замаар хариуцлагатай хэрэглээг бүх талаар дэмжин сурталчахыг зоржь байна.

TX3-д оруулж буй хувь нэмэр:

TX3-д оруулж буй хувь нэмэр:



Бага болон алкохолгүй бүтээгдэхүүний инновацыг түүчээлэх

Согтууруулах ундаа уухыг хүсдэггүй хэрэглэгчдэд тохирсон бүтээгдэхүүнээр хангах тал дээр анхааран ажиллаж байна. Бидний зорилго бол бага болон огт алкохолгүй ангиллын талаарх хэрэглэгчдийн эерэг ойлголтыг бий болгох маркетингийн кампанит ажлуудаар дэмжиж, алкохолны агууламжгүй ундааны сонголтыг бий болгох явдал юм. Энэ дагуу бид Heineken 0.0 брэндийг Монголд танилцууллаа. Согтууруулах ундааны 0.0% ангилал 2020 онд дэлхийн хэмжээнд 4.7% -иар өссөн байна. (Эх сурвалж: Heineken)

Solar power энергийн ундаа

Бид энергийн ундаа, алкохолгүй ундааны ангилалд Solar Power брэндийг Монголд нийлүүлж байна. Solar power нь эрч хүчээр хангахын тулд зөвхөн байгалийн

орц найрлагыг ашигладаг бөгөөд бусад энэ төрлийн бүтээгдэхүүнүүдээс бага хэмжээний сахар агуулдаг гэдгээрээ онцлогтой.

БАЙГАЛИЙН ХҮЧИЙГ МЭДЭР





АМЬДРАЛЫН МӨЧ
БУРИЙГ ХАМТДАА